



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/367

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх ажилд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны "Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж"-ийн 5.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, уснаас эрэн хайх ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 33,500,000 (гучин гурван сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардлагатай багаж хэрэгслийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулах, иргэдэд ухуулга сурталчилгааны тараах материал, сэрэмжлүүлэг самбар байршуулах арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Зардлын тооцоо

д/д	Уснаас эрэн хайх аврах багаж, хувцасны нэр	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Жет мотор Parsun TP30 (30морины хүчтэй)	11.000.000	2	22.000.000
2	Авакан 430 JET хийлдэг завь	6.100.000	1	6.100.000
3	Завины хамгаалалтын тоноглол	400.000	1	400.000
4	Бүрэн комплект шумбалтын хувцас (5мм)	1.000.000	4	4.000.000
5	Аврах хантааз	100.000	10	1.000.000
Нийт				33.500.000